

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ
ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН 2018 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРАЛД ХИЙСЭН АЖЛЫН
МЭДЭЭЛЭЛ

2018.03.26

Хяналт шинжилгээ-үнэлгээ дотоод аудитын хэлтэс нь ажлаа улирлаар, мэргэжилтнүүд сараар төлөвлөн үйл ажиллагаагаа явуулж байна. 1 улиралд 20 асуудлыг төлөвлөн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг 95 хувьтайгаар хэрэгжүүлэн ажиллалаа. Сумдад онлайн хурал хийж 2017 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүн, цаашид авах арга хэмжээний талаар мэдээлэл хийх байсан боловч тоног төхөөрөмж нь эвдэрсэн тул хийгээгүй тасарсан байна.

Төрийн байгууллагуудын 2017 оны үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийлгэхээр "Говийн хөгжил наран" ТББ- тай гэрээ байгуулан хэрэглэгчийн үнэлгээ хийлгэж, ажлын хөлсийг ЗДЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн төсөл арга хэмжээний зардлаас Гурван сая төгрөг гаргаж шийдвэрлүүлсэн.

Дундговь аймгийн ЗДТГ, Засаг даргын дэргэдэх 21 агентлаг, 15 сумын төрийн байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийн өнөөгийн байдал, сайжруулах арга замыг тодорхойлох зорилготой 15 сумаас авсан судалгаанд нийт 550 хүн, аймгийн ЗДТГазар болон 21 хэлтэс агентлагийн үйлчилгээний чанар хүртээмжийн судалгаанд давхардсан тоогоор 719 хүн хамрагдсан байгаа нь аймгийн насанд хүрсэн нийт иргэдийн 1.8 -2,4%-ийг эзэлж байна. Аймгийн ЗДТГ-ын хэрэглэгчийн үнэлгээний дүн 62,5 хувьтай үнэлэгдсэн бөгөөд 21 агентлаг, 15 сумын хэрэглэгчийн үнэлгээний дүнг 2017 оны жилийн эцсийн ХШҮ-ний дүнд аргачлалын дагуу оруулж тооцсон болно. Сумдад иргэдийн өмнө тулгамдсан асуудлын саналыг сумдын удирдлагуудад танилцуулж, цаашид ажилдаа тусган хэрэгжүүлэх, анхааралдаа авч ажиллахыг зөвлөмж болгоод байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт аймгийн ЗДТГ-ын 2017 оны жилийн эцсийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хүргүүлээ. Үүнд, Засгийн газрын гишүүн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт 2017 оны хэрэгжилт 92,4 хувь, Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт 91.67 хувь, байгууллагын ил тод байдлын хэрэгжилт 93.65, эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт 90.77 хувьтайгаар хяналт шинжилгээ үнэлгээ хийгдсэн байна. Үнэлгээний тайланг 3 дугаар сарын 29 –нд ЗГХЭГ-т хүргүүлсэн.

2017 оны сүүлийн хагас жилд хэрэгжсэн хууль тогтоомж шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, үнэлгээний дүнг Засаг даргын зөвлөлийн 2018 оны 01 сарын 03-ны өдрийн 01 дүгээр хуралд танилцуулан программд шивж оруулж, нийт 75 эрх

зүйн актын 104 заалтыг хяналтад авч 100 хувь -70, 70 хувь-24, 30 хувь-1, хэрэгжилт тооцох хугацаа болоогүй 9 заалт байгаа бөгөөд хэрэгжилтийн дундаж хувь 91,6 байна.

Аймгийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд үнэлгээ хийж нийт 105 арга хэмжээнээс 100 хувь -93, 70 хувь -23, 30 хувь -6, үнэлэх боломжгүй - 8 заалт байна. Дундаж үнэлгээ 91,2 хувьтай байлаа. Тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2/147 тоотор ЗГХЭГ-т хүргүүлсэн.

ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2017 оны төлөвлөгөөний 86 заалтад хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд үр дүнтэй буюу 100 хувьтай 48, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70 хувьтай 11, эрчимжүүлэх шаардлагатай 40-4, үнэлэх боломжгүй 23 заалтын биелэлт 90.95 хувьтай байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан цахим программд оруулж хугацаанд нь баталгаажуулсан.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2018 оны төлөвлөгөөний төслийг гаргаж, хэлтсүүдээр хянуулан программаас хасуулах саналтай 13 заалт арга хэмжээг нэгтгэн ЗГХЭГ-т хүргүүлээд байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 2017 оны жилийн эцсийн хэрэгжилтийг нэгтгэн, хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 198 заалтын биелэлт 92,71 хувьтай хэрэгжиж байна. Тайлангуудыг ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлэн үнэлгээний дүнг аймгийн сайт болон able программын олон нийтийн файлын санд байршуулахаас гадна АС цогцолбороор мэдээлсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2017 оны үйл ажиллагааны тайлангийн хураангуйг гаргаж Тамгын газрын даргын 2/315 тоотор ЗГХЭГ-т хүргүүлсэн. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнгийн 9 төрлийн тайланд хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд үнэлгээний дундаж 88,8 хувьтай байна.

Сум агентлагийн 2017 оны үйл ажиллагаанд үнэлгээ хийх аргачлалыг нарийвчлан боловсруулан батлуулж сум агентлагуудад хүргүүлэн ажлын хэсгийн хурлыг 2 удаа хийж аргачлалын талаар ярилцлаа. Малын халдварт өвчин гарсан 4 суманд очиж үнэлгээ хийх боломжгүй учраас тайлан мэдээ ирүүлэх талаар тоот хүргүүллээ. Мөн цахим хурал хийж сумдуудад 2017 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх аргачлал, цаг үеийн асуудлаар мэдээлэл өгсөн.

Сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, агентлагийн 2017 оны үйл ажиллагааны үр дүнд ХШҮ-г 3 ажлын хэсэг томилогдон ажиллаж, Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, агентлаг, сумдын ЗДТГ-ын 2017 оны үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээний дүнг нэгтгэн ЗДЗ-ийн 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 3 дугаар хуралдаанд

танилцуулан үнэлгээний дүнг аймгийн Засаг даргын 2018 оны А/49, А/50 тоот захирамжаар баталгаажууллаа. Үнэлгээний дүнгээр агентлагуудаас Мэргэжлийн хяналтын газар 96.16 хувиар Нэгдүгээр байр, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар 96.15 хувиар Хоёрдугаар байр, Байгаль орчин, аялал жуулчлалын газар 95.41 хувиар Гуравдугаар байр, сумдаас Сайнцагаан сум 90.85 нэгдүгээр байр эзэлсэн. 2018 оны үнэлгээний дүнгээр 10 агентлаг “Санаачилгатай сайн”, бусад агентлаг “Хэвийн”, сумдаас 1 сум “Санаачилгатай сайн”, бусад сум “Хэвийн” гэсэн үнэлгээ авсан байна. Сум, агентлагийн шагналыг гардуулж өглөө.

Хэлтсээс АС цогцолборын хуулийн цаг, мэдээллийн цаг, байгууллагын хуралд мэдээлэл хийх хуваарийг нарийвчлан боловсруулж хэлтсийн даргаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдөж эхэллээ.

АС цогцолборын хуулийн цаг, мэдээллийн цагаар Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого, Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, Сум, хэлтэс агентлагийн 2017 оны үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээний дүн, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2017 оны хэрэгжилтийн тухай зэрэг сэдвүүдээр мэдээлэл хийсэн.

Байгууллагын хуралд хуваарийн дагуу байгууллагын 2018 оны дотоод хяналтын төлөвлөгөө, тайланг мэдээ ирүүлэх хугацаа, хуваарь, аймгийн Засаг даргын эхний 3 сард гаргасан захирамжийн хэрэгжилтэд хийсэн дотоод хяналтын талаар мэдээлэл хийсэн.

Байгууллагын 2018 оны дотоод хяналтын төлөвлөгөөг 7 асуудалд хийхээр боловсруулан батлуулж хэлтсүүдэд хүргүүлсэн.

Байгууллагын няравын үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтын байдалд 2017 онд хийсэн дотоод хяналт хийсэн илтгэх хуудас зөвлөмжийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн дарга болон няравт тоотоор хүргүүлж, хэрэгжилтийг 2018 оны 5 сард шалгахаар төлөвлөгөөнд тусгалаа.

Аймгийн Засаг даргаас батлан гаргасан захирамжийн хэрэгжилтэд дотоод хяналт хийлээ. 3 сарын 23-ны байдлаар 117 захирамж гарсан байна. Үүнээс 54 захирамжийг аймгийн сайтын эрх зүйн акт хэсэгт байршуулж 63 захирамжийг байршуулаагүй байна. Аймгийн Засаг даргын 2017 оны А/91 тоот захирамжийн дагуу “Санал авах хуудас”- аар санал авч Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлэх ажил төдийлөн хангалтгүй, үг үсгийн алдаатай гарч байгаа тул захирамжийн төсөл боловсруулж байгаа хэлтэс агентлагууд, ажилтнууд анхаарч ажиллах шаардлагатай байна. Мөн “Санал авах хуудас”-аар санал авах ажил дутагдалтай байна.

Аймагт 2018 онд хэрэгжих 11 яам, газрын 56 үндэсний хөтөлбөр болон 3 хэлтсийн 18 дэд хөтөлбөр байна. Сумдад хамааралтай 6 яамны 38 үндэсний хөтөлбөр болон аймгийн 18 дэд хөтөлбөрийн жагсаалтыг шинэчлэн гаргаж сум, байгууллагуудад able программаар хүргүүлэн хяналтад авахуулан ажиллалаа.

Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөөний сумдад холбогдолтой заалтыг түүвэрлэн гаргаж сумдуудад АБЛЕ программаар хүргүүлсэн.

2018 онд явцын Хяналт шинжилгээ хийх төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэлтэс, агентлагуудад хүргүүлэв.

МЭДЭЭЛЭЛ БИЧСЭН:

ХШУДАХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Э.ОДОНЧИМЭГ